



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/105

Хэрлэн сум

Гамшигтай тэмцэх арга хэмжээнд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/101 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн өвөлжилт, хаваржилт хүндэрсэн зарим сумдад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Хөдөө аж ахуйг дэмжих сангаас дэмжлэг үзүүлж байгаа 750 тонн тэжээлийн буудайг татан авахад шаардагдах 117.628.000 (нэг зуун арван долоон сая зургаан зуун хорин найм мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Шаардлагатай шатахуун, бараа материалын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Бараа материалын тээвэрлэлт, тэжээлийн буудайг хуваарийн дагуу олгох ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Энх-Амгалан)-д даалгасугай.

4.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
дүгээр сарын 23-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

A/193

Шаардагдах тооцоо

д/д	Зардлын төрөл	Мөнгөн дүн
1	Шатахуун	48.740.000
2	Тээврийн зардал	57.719.000
3	Хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл, хангалт	2.769.000
4	Малчдад хүнсний багц	8.400.000
	Нийт	117.628.000